

БАТЛАВ:
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
.....Б.ЛХАГВАМАНДАЛ
.....О.ЛХАГВАСҮРЭН

БАТЛАВ:
“ҮЛЭМЖ ХУРД” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН УСАН ХАНГАМЖ, АРИУТГАХ
ТАТУУРГЫН БАЙГУУЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗҮГШРҮҮЛЭХ ТҮР ГЭРЭЭ**

№ДУЭДЗДТГ/2022/11/18

2022 оны 10 дугаар сарын 01-ны өдөр

Сангийн далай

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Энэхүү гэрээг нэг талаас Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Засаг даргын Тамгын газар (цаашид "Захиалагч" тал гэнэ), түүнийг төлөөлж ЗДТГ-ын дарга Галбаатар овогтой Энхдэлгэр, нөгөө талаас “Үлэмж хурд” ХХК-ий нягтлан бодогч Бямбасүх овогтой Эрдэнэтуяа (цаашид "Ашиглагч" тал гэнэ) бид дараахь нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

1.2.Энэ гэрээ нь 2 хувь байх ба талууд гарын үсэг зурж баталгаажсанаар хүчин төгөлдөр болно.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Гэрээний талууд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.15 дах заалт, Иргэний хууль тогтоомж болон бусад хууль тогтоомж, холбогдох эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэдалай суманд баригдсан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулж цэвэршүүлэх үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй байлгах зорилгоор “Үлэмж хурд” ХХК-д цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны

менежментийг шилжүүлэн хамтран ажиллах харилцааг зохицуулах, хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1. Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулж цэвэршүүлэх үйлчилгээг чанартай гүйцэтгэхэд шаардлага тавих

3.2. Гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт тавих

3.3. Гэрээнд заагдсан нөхцөлийн дагуу ажлыг хэрэгжүүлсэнтэй холбогдуулан тодорхой дэмжлэг үзүүлнэ.

3.4. Ашиглагч талд цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулж цэвэршүүлсэн үйлчилгээ авсан төсөвт байгууллагын зардлыг батлагдсан төсвийн хүрээнд сар бүр шилжүүлүүлэх ба үнийн өөрчлөлттэй холбогдуулан санхүүжилтийг өөрчилж болно

3.5 2022 оны 10,11,12-р сарын нийт төлбөр 6 сая төгрөгийг цэвэр, бохир ус ашиглагч байгууллагуудын цэвэр бохир усны зардлын 2022 оны хэмнэгдсэн төсөвт багтааж шинээр бий болсон үйлчилгээ, хэмжих тоолуур тавигдаагүй, байгууллагын цэвэр, бохир ус ашиглах хэмжээ зэргийг харгалзан харилцан уян хатан нөхцөлөөр тохиролцож энэхүү гэрээг үндэслэн /Бүрэн дунд сургууль-2 сая, ЭМТ-1,5 сая, Соёлын төв-1 сая, Хүүхдийн цэцэрлэг-1,5 сая / тооцож гүйцэтгэгч байгууллагад шилжүүлэх.

Дөрөв. Ашиглагч эрх, үүрэг

4.1. Энэ чиглэлээр Монгол Улсад мөрдөгдөж буй бүх хууль тогтоомж, дүрэм журам, стандартуудыг дагаж мөрдөх.

4.2 Ашиглагч стандартын шаардлага хангасан цэвэр усаар тасралтгүй хангаж бохир усыг татан зайлуулж, цэвэршүүлнэ

4.3. Захиалагч талтай тохиролцсон санхүүжилтийг авах ба онцгой тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулж санхүүжилтийн хуваарийг өөрчилж болно

4.4 Энэхүү гэрээний хүрээнд дараах үйл ажиллагааг тасралтгүй байнга явуулна. Үүнд:

4.4.1. Айл өрх, албан газрын цэвэр ус түгээлт, бохир ус татан зайлуулж, цэвэршүүлэх үндсэн үйл ажиллагааг тасралтгүй, чанартай явуулах.

4.4.2. Үйл ажиллагааг хянах зорилгоор холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд нээлттэй байлгаж урсгал болон их засвар үйлчилгээний ажлыг тогтмол чанартай гүйцэтгэх

Тав. Гэрээний хугацаа

5.1. Гэрээний хугацаа 2022 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс, 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуусталх хугацаанд байна. Гэрээний хугацааг талууд тохиролцон сунгаж болно.

Зургаа. Гэрээний санхүүжилт

6.1. Захиалагч нь ашиглагчид үйлчилгээний төлбөр болон бусад зардлыг нэхэмжлэлийн дагуу ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэгчид олгоно.

6.2. Захиалагч /төсөвт байгууллагууд/ нь гэрээний дагуу санхүүжилтийг ашиглагч болох “Үлэмж хурд” ХХКомпаний Хас банк дахь 5002808282 тоот дансанд шилжүүлнэ.

Долоо. Талуудын хүлээх хариуцлага, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

7.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь нөхөн төлөх үүрэгтэй.

7.2. Энэхүү гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

Найм. Маргаан, гомдол

9.1 Энэхүү гэрээний биелэлт, үнэлэлтийн талаар гомдол, маргаантай асуудал гарвал хоёр тал албан харилцааны хүрээнд эвийг эрхэмлэн шийдвэрлэнэ.

9.2 Харин харилцан шийдэлд хүрээгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Гэрээний баталгаажуулалт

10.1 Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн:

<p>ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА Г.ЭНХДЭЛГЭР</p> <p>РД: 9033629 ХАЯГ: ЭРДЭНЭДАЛАЙ СУМ, УТАС: 99058611, 99068721</p>	<p>АШИГЛАГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ: "ҮЛЭМЖ ХУРД"ХХК-НИЙ НЯГТЛАН БОДОГЧ</p> <p>Б.ЭРДЭНЭТУЯА РД: 2681307 ХАЯГ: ӨВӨРХАНГАЙ АЙМАГ, УТАС: 88119394, 99322848</p>
